MMINFO.

# МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Хүн ам 3,115.147... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.11.11. Баасан. №201 (4571) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

**УЛС ТӨР**

359 КОМПАНИ НЭР ДЭВШИГЧДЭД ХОЁР САЯ ТӨГРӨГӨӨС ДЭЭШ ХАНДИВ ӨГЧЭЭ

**II нүүрт**

**ДЭЛХИЙ**

АМЕРИКЧУУД ЭСЭРГҮҮЦЛИЙН ЖАГСААЛД ШИЛЖЛЭЭ

**IV нүүрт**



# Л.ЦЭНД:

## БИДЭНД СЭТГЭЛЭЭСЭЭ АЖИЛЛАХ ДАСГАЛЖУУЛАГЧ ХЭРЭГТЭЙ БАЙСАН, ТЭГЭЭД Д.ЭНХБАЯРЫГ АМЕРИКААС ДУУДАЖ БАЙЛАА

**Дэлгэрэнгүй ярилцлагыг V нүүрнээс**

ҮЗЭЛ БОДОЛ

# ХЭН ЮУ ХЭЛЭВ

Э.ТУУЛ

*Өнгөрсөн долоо хоногийн чуулганы хуралдаанаар чамгүй олон асуудал хэлэлцэн шийдвэрлэсний дотор ард түмний амьдралд ойр, хөрсөн дээр буусан шийдвэрүүдийг баталсан нь онцлох үйл явдал байлаа. Энэ дунд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Төсвийн тухай хуулийг дагалдан өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд болон УИХ-ын тогтоолын төсөл, ахмад настанд олгох “Насны хишиг”, хүүхэд харах үйлчилгээний тухай асуудал гэх зэрэг шийдвэрээ хүлээсэн олон асуудал багтсан юм. Үүнээс гадна Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нөхөн төлүүлэх тухай хуулийн төслүүдийг ч хэлэлцэж эхлээд буй. Түүнчлэн өнгөрсөн долоо хоногт онцлох нэгэн үйл явдал болсон нь экс Ерөнхий сайд Н.Алтанхуяг Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшинэ гэдгээ зарласан юм. Ингээд дээрх асуудлын хүрээнд хэн юу хэлсэн талаар “Хэн юу хэлэв” булангийнхаа энэ удаагийн дугаарт онцолж байна.*

### С.Чинзориг: Ээжүүдийн нийгмийн даатгалын шимтгэл, улсад ажилласан жил тасалдахгүй

*/УИХ-ын гишүүн/*

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нөхөн төлүүлэх тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж эхлээд байгаа.

**Үргэлжлэл нь III нүүрт**

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**




Дугаарын 60 мөр

# Цахилгааны шөнийн тарифыг тэглэе

Ж.ОТГОНМЯГМАР

Сая гаруй хүн амтай Улаанбаатар хотын хамгийн хэцүү асуудал бол гамшгийн хэмжээнд хүрээд байгаа утаа. Мэдээж агаарын бохирдлын хор уршиг нь шууд хүнд тусдаг.Тэгэхдээ утааны хорт нөлөө хэнийгч ялгалгүй хүн бүрт адилхан нөлөөлдөг нь аймшигтай. Өөрөөр хэлбэл, хөөрхий жирэмсэн, ахмад настай, нярай хүүхэд юм хэмээн ангилахгүй. Бүр хэчнээн их мөнгө хөрөнгөтэй амьдралаас тасарчихаад байгаа тэргүүн баячуудыг ч ялгахгүй хордуулдаг. Хамгийн эмгэнэлтэй нь хорт утаа эхийн урагт ихээхэн нөлөөлөхөөс гадна төрөлтийн эндэгдэл их байгаа нь харамсалтай. Өөрөөр хэлбэл, бяцхан үрс маань хорт утаанаас болж эхийн гэдсэндээ буюу хорвоод мэндэлж амжаагүй амиа алдаж байна. Харин утааны хор уршгийг тэсвэрлэж чадсан нэг нь эхээс төрөхдөө л төрөлхийн элдэв янзын өвчин эмгэг, эрхтэн дутуу төрж байгаа нь нууц биш.

**Үргэлжлэл нь III нүүрт**




ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

# 2017 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙГ БАТАЛЛАА

Ж.ОТГОН

*УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2017 оны төсвийн тухай, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах Үндсэн чиглэл батлах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хэлэлцэн баталлаа. Түүнчлэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийдлээ. Тус хуулийн төслүүдээр оффшор дансыг асуудлыг зохицуулахаар тусгасан юм.*

### Тав хоногийн өмнө ирэх оны төсвийг баталлаа

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2017 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хэлэлцэн баталлаа. Холбогдох хуулиар дараа оны төсвийг арваннэгдүгээр сарын 15-ны дотор батална гэсэн байдаг. Тэгвэл УИХ түүнээс тав хоногийн өмнө ирэх оны төсвийг ийнхүү баталлаа. 2017 оны төсвийн төсөлд тусгаснаар Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 6.160.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 23.3 хувь, нийт зардал 8.568.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 32.3 хувь болж, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн алдагдал 2.408.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 9.1 хувь болж, Засгийн газраас өргөн барьсан төслөөс 0.8 хувиар буурсан аж.

**Үргэлжлэл нь II нүүрт**




| | ХААН банк | | | | | Худалдаа хөгжлийн банк | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Авах | Зарах | | Авах | Зарах | | Авах | Зарах | | Авах | Зарах |
| АМ.ДОЛЛАР | 2450.00 | 2484.00 | ФУНТ | 2969.00 | 3147.00 | АМ.ДОЛЛАР | 2452.00 | 2484.00 | ФУНТ | 3011.00 | 3148.00 |
| ЕВРО | 2699.00 | 2765.00 | РУБЛЬ | 36.70 | 40.80 | ЕВРО | 2653.00 | 2774.00 | РУБЛЬ | 37.35 | 41.36 |
| ИЕН | 22.86 | 24.01 | ЮАНЬ | 360.00 | 368.40 | ИЕН | 23.00 | 24.11 | ЮАНЬ | 360.00 | 368.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

# 2017 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙГ БАТАЛЛАА



**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Мөн улсын төсвийн орлого, зарлагын өөрчлөлттэй уялдуулан Нийгмийн даатгалын сангийн орлогыг 10.6 тэрбум төгрөгөөр нэмэн 1.978.0 тэрбум төгрөг, тус сангийн зарлагыг 0.7 тэрбум төгрөгөөр бууруулан 1.877.4 тэрбум төгрөг байхаар тооцож, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгасан байна.

Ирэх 2017 онд зэсийн баяжмалын экспортоос төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн орлогын гурван хувиас давахаар байгаа тул Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу зэсийн үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцжээ. Ирэх оны төсөвт нэг тонн цэвэр зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 4.599.0 ам.доллар, зах зээлийн үнийг 4.800.0 ам.доллар байхаар тооцож, Тогтворжуулалтын санд 7.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцсон байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2017 онд тухайн жилийн ДНБ-ий 9.9 хувиас илүүгүй байх юм. Харин Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн төсөлд туссан Засгийн газрын шинээр авах зээл, гаргах үнэт цаас, өрийн баталгаа, тэдгээрийн эргэн төлөлт болон Засгийн газрын өрийн удирдлагын бодлого, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зохицуулалтын арга хэмжээг оруулан тооцсоноор 2017 оны эцэст Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа нь 84.8 хувьд хүрэх төлөвтэй байгаа нь Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг бүрэн хангаж байна гэж хууль боловсруулагчид үзжээ.

Үүний дараа ирэх төсвийн тухай хууль батласантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийв. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулж асуулт асуух гишүүн байсангүй. Иймд дараагийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

## Б.Пүрэвдорж: МАН–ын 65 гишүүн өөрийнхөө намын оффшорчидоо хамгаалсан хууль гаргаж байна

Чуулганаар нэлээд хүлээлт үүсгээд байсан төрийн дээд албан тушаалтан оффшор дансгүй байх тухай хуулийн төслийг хэлэлцэв. Өөрөөр хэлбэл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг дэмжлээ. Тус хуулийн төслүүдээр оффшорын асуудлыг зохицуулахаар тусгасан юм.

### ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ШАТАНД

**УИХ-ын гишүүн Г.Занданшатар:** Энэ хуулийн талаар би сонин ойлголттой байна. Бусад улсад ил тод байдлыг хангахыг шаарддаг болохоос хориглоод байдаггүй юм байна лээ. Хоёрдугаарт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өөрчлөхгүй бол Үндсэн хуультай утга санаа зөрчилдөж байгаа.

**Хууль зүй дотоод хэргийн сайд Ц.Бямбацогт:** Сүүлийн жилүүдэд олон нийтийн дунд төрийн албан хаагчдыг оффшор бүс, гадаад улсад банкны данс болон гадаадын хөрөнгө оруулалттай компаний хувьцаа эзэмшсэн тохиолдолд авлига, албан тушаалын хэрэгтэй холбоотой гэх хардлага эрс нэмэгдэж, төрд итгэх иргэдийн итгэл буурч байна. Иймд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зорилтыг хангах, төрд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах зорилгоор Авлигатай тэмцэх газарт хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг төрийн албан хаагчдыг гадаад улсын нутаг дэвсгэрт банкны данс эзэмших, мөнгөн хөрөнгө байршуулах, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулах асуудлыг хориглох талаар зохицуулалт хийх зайлшгүй шаардлага тулгарч байна. Иймд дээрх хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх, ёс зүйн хэм хэмжээг баримтлах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулллаа. Ингэхдээ албан тушаалтны гадаад улсад суралцах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зэрэг үндсэн эрх, бусад хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх хугацаанд оффшор бүсэд оршин суух, зорчих зэрэг хэрэгцээ шаардлагыг харгалзан тухайн улсын банкинд өөрийн нэр дээр данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах асуудлыг хориглолтонд хамруулахгүй байхаар зохицуулсан.

> ...Энэ хуулийг татаж авсангүй харамсалтай байна. Уг нь бидний хийх ёстой алхам бол оффшортой тэмцэж байгаа олон улсын гэрээнд яаралтай нэгдэх хэрэгтэй. Хууль зүйн сайд хууль эргэж үйлчилдэггүй өмнөх оффшорчдод хамаагүй гэж тайлбар хийж байна. Хэрэв ингэж үзэж байгаа бол энэ хууль гарах ёсгүй...

**УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж:** Энэ хуулиар өмнөх оффшорчдоо хэрхэн гаргаж, яаж шийтгэх юм бэ гэдэг нь тодорхойгүй байна. МАН-ын 21 оффшорчин байгаа шүү. АН-аас нэг оффшорчин байгаа. Энэ хүмүүсээ яах юм бэ. Хуулийг төслийг харахад, эрх баригч МАН-ынхан өөрийнхөө намын 21 оффшорчиноо хамгаалах чиглэлд илүү яваад байна. Хуулиас харж байхад өмнөх оффшорчин нөхдүүдийг яах ч үгүй. Харин шинээр гарч ирэх оффшорчид хохино шүү гэдгээр хандсан байна.

**Хууль зүй дотоод хэргийн сайд Ц.Бямбацогт:** Хууль эргэж үйлчилдэггүй гэсэн зарчим байдаг. Гэхдээ С.Баярцогтын оффшор илэрсэн үед энэ хуулийг баталсан бол тухайн үед ил болсон оффшорчдод хариуцлага хүлээлгээдявахбайсан.Тиймээс цаг алдахгүйн тулд энэ хуулийн төслийг оруулж ирж байна. 21:1 гэсэн тоо бол худлаа шүү. Тантай санал нийлэхгүй байна. АН-аас Э.Бат-Үүл даргын хүү, С.Баярцогт, УИХ-ын гишүүн асан Кекүшьюзан Батбаяр зэрэг олон хүн байдаг.

**УИХ-ын гишүүн Х.Болорчулуун:** Оффшорчин хүн данс, эсвэл оффшор бүсд байгуулсан компаниа өөрийн нэр дээр байгуулдаггүй гэсэн олон баримт бий. Ихэвчлэн гэр бүлийнхээ аль нэг гишүүний нэр дээр байгуулдаг. Тэгэхээр тухайн оффшорчин гэр бүлийн аль нэг гишүүний нэр дээр оффшор данс нээсэн бол тухайн гэр бүлийн гишүүнд хариуцлага хүлээлгэх асуудал байгаа юу.

Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Н.Энхбаяр: Аливаа хуулийг Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулдаг. Гэр бүлийн гишүүдийг хамруулж, хүрээг нь өргөжүүлэх эсэх асуудал дээр нэлээд ярилцсан. Үндсэн хуулийн 16 зүйлийн 14-т гэмт хэрэгт гэр бүлийн гишүүдийг хамруулж болохгүй гэж тодорхой заасан байгаа. Түүн дээр үндэслэн гэр бүлийн гишүүдийг хамруулж, өргөжүүлээгүй.

**УИХ-ын гишүүн Х.Болорчулуун:** Нууц данстай эрхмүүдийг ил болгохыг ард түмэн хүсч байгаа. Яригдаад байгаа 40,50 хүний хэн нь хэдэн төгрөг хадгалагдсан нь мэдэгдэхгүй байна. Тиймээс олон улсын байгууллагатай хамтарч энэ асуудлыг илрүүлэх талаар хийсэн алхам байна уу. Хоёрдугаарт, төрийн болон төрийн өндөр албан тушаал хашиж байсан хүмүүс гэж байна үүн дотор гэр бүлийн хүмүүс гэж оруулах нь зүйтэй болов уу гэж бодож байна. өөрийнхөө нэрээр гадаадад мөнгө хадгалдаг хүн байдаггүй юм.

Ажлын хэсгийн төлөөлөгч: Таны хэлснээр гэр бүлийн хамаарал бүхий гишүүнийг оруулж ирэх үү, үгүй юу гэж нэлээд ярьсан. Гэхдээ хууль бол Үндсэн хуульд захирагдах ёстой. Ингэхэд Үндсэн хуультай зөрчилдөж байсан. Тиймээс гэр бүлийн гишүүдийг хамаатуулаагүй юм.

**УИХ-ын гишүүн Л.Болд:** Энэ хуулийг татаж авсангүй харамсалтай байна. Уг нь бидний хийх ёстой алхам бол оффшортой тэмцэж байгаа олон улсын гэрээнд яаралтай нэгдэх хэрэгтэй. Хууль зүйн сайд хууль эргэж үйлчилдэггүй өмнөх оффшорчдод хамаагүй гэж тайлбар хийж байна. Хэрэв ингэж үзэж байгаа бол энэ хууль гарах ёсгүй. Оффшор данс эзэмшдэг хүмүүсээс тайлбар авах хэрэгтэй. Тиймээс энэ хуулийн төслийг буцаан татаж аваач. Энэ асуудалд нам ямар ч хамаагүй байх ёстой.

Ийнхүү Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлторуулахтухайхуулийн төсөл, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг гишүүдийн 64.8 хувь нь хэлэлцэх ёстой гэж үзээд, дэмжив. Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.


MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.


ШАР мэдээ



## Сангийн сайд Б.Чойжилсүрэн “банга” хүртэх үү

Сангийн сайд Б.Чойжилсүрэнд Засгийн газраас “биелэгдэшгүй” даалгавар өглөө. Тэр нь өдөр бүр өсөн нэмэгдэж байгаа валютын ханшийг тогтоон барих. Аль хэдийнэ 2500-г давж, өнөө маргаашгүй 3000 төгрөгтэй тэнцэхдээ тулаад буй ам.долларын ханшийн өсөлтийг Сангийн сайд хэрхэн буулгах эсэх нь тааамаг болоод байна. Уг нь эдийн засагчдын хэлж буйгаар ам.долларын ханшийг бууруулах арга замыг гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гээд байгаа. Гэтэл хөрөнгө оруулагчид Монголыг тоохгүй байсаар. Үүний шалтгаан нь Сангийн сайдын хариуцлагагүй мэдэгдэл, Засгийн газрын бас бус үйл ажиллагаатай шууд холбоотой гэдгийг учир мэдэх хүмүүс хэлж буй. Товчхондоо бол өөрсдийнхөө "баасан дээрээ хальтарна" гэдэг нь болж байх шиг байна. Харин одоо уснаас хуурай гарах арга хайж, өнөөх Сангийн сайддаа үүрэг өглөө. Тэгвэл Сангийн сайд валютын ханшийн өсөлтийг барьж чадахгүй, барих аргыг олохгүй бол Б.Чойжилсүрэнгээ огцруулах болов уу. Эсвэл...

МЭДЭЭЛЭЛ

## 359 компани нэр дэвшигчдэд хоёр сая төгрөгөөс дээш хандив өгчээ

Үндэсний аудитын газраас 2016 оны УИХ-ын сонгуульд өрсөлдсөн нам, эвсэл нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг гаргаад байна. Энэ удаагийн УИХ-ын сонгуульд 12 нам, гурван эвсэл, 496 нэр дэвшигч өрсөлдсөнөөс 11 нам, хоёр эвсэл, 386 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд Үндэсний аудитын газар дүн шинжилгээ хийснээ олон нийтэд ил болголоо. Учир нь нэг нам, нэг эвсэл, 100 орчим нэр дэвшигч сонгуулийн зардлаа тайлангаа Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй аж. Сонгуулийн тухай хуульд заасанаар заасан хугацаанд зардлын тайлангаа ирүүлээгүй нам, эвсэл, нэр дэвшигч нь дараагийн сонгуульд өрсөлдөх боломжгүй болно.

Өөрөөр хэлбэл, 2020 оны УИХ-ын сонгуульд өрсөлдөх эрх нь хязгаарлагдана гэсэн үг юм. Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар 2016 оны УИХ-ын сонгуульд өрсөлдөж буй нам, эвсэл тус бүрийн сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг 4.4 тэрбум төгрөгөөр тогтоосон. Энэ нь өмнө батлаад байсан сонгуулийн зардлын дээд хэмжээнээс даруй нэг тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт байв. Сонгуулийн зардал өссөн шалтгааныг тойрог нэмж байгуулагдсантай холбоотой хэмээн тайлбарлаж байсан юм. Үндэсний аудитын газраас гаргасан мэдээгээр сонгуулийн тайлан ирүүлсэн нам, эвслүүд нийт дүнгээрээ 8.363.9 сая төгрөгийн орлогыг сонгуульд зориулан төвлөрүүлжээ. Үүний 4.549.5 сая төгрөг нь иргэнээс, 853.1 сая төгрөг нь хуулийн этгээдээс өгсөн хандив ээлсэн бол 2.961.3 сая төгрөг нь нам, эвсэл нэр дэвшигчдийн орлогоос бүрдсэн аж. Мөн УИХ-ын ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансанд нийт 26.593.3 сая төгрөг төвлөрсний 203.4 сая төгрөг нь нам, эвслийн хөрөнгө бол 7.629.0 сая төгрөг нь нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, 18.760.9 сая төгрөг нь хандиваар цугларсан орлого ээлнэ. Тайлан ирүүлсэн 386 нэр дэвшигчдэд иргэдээс 14.511.7 сая, хуулийн этгээдээс 4.249.2 сая төгрөгийн хандив төвлөрчээ. Харин УИХ-ын сонгуульд нэр дэвшигчид 26.010.9 сая төгрөгийг сонгуульд зориулан зарцуулсан аж. УИХ-ын сонгуульд өрсөлдсөн нам, эвсэлд хоёр сая төгрөгөөс дээш хандив өгсөн 75 аж ахуйн нэгж 845.0 сая төгрөгийг, нэг сая төгрөгөөс дээш хандив өргөсөн 1673 иргэнээс 4.239.5 сая төгрөг тус, тус төвлөрчээ. УИХ-ын сонгуульд нэр дэвшин өрсөлдсөн нэр дэвшигчдэд хоёр сая төгрөгөөс дээш хандив өргөсөн 359 компани байсан бөгөөд 3.945.0 сая, нэг сая төгрөгөөс дээш хандив өргөсөн 5706 иргэнээс 13.286.5 сая төгрөгийн хандив тус, тус төвлөрсөн байна.

# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




*Ерөнхийлөгчийн зөвлөх*

*Ч.Өнөрбаяр*



## Цахилгааны шөнийн тарифыг тэглэе

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тэгвэл тэдгээр хүүхдүүд эрхтэн дутуу төрүүлсэн гээд ээждээ гомдох уу, энэ асуудлыг шийдэж чадахгүй байгаа эх орондоо гомдох уу. Утааг бууруулах хүрээнд төр Засгаас худлаа, үнэн олон ажил хийсээр ирсэн. Гэтэл өнөө жилээс утаатай тэмцэх үлгэн, салган тэмцэл зогсож байгаа сурагтай.

Уг нь хорт утаа гэдэг хойш нь тавихгүй нэн яаралтай шийдэх тулгамдсан асуудал байлтай. Сүүлийн жилүүдэд нийслэлийн бүх хүн ам амьсгалын замын болон зүрх судасны өвчлөл, артерийн даралт ихсэх, астма, бронхит, харшил, уушигны цэврүүт өрөвсөл зэрэг өвчлөлд байнга нэрвэгдэж байгаа. Эдгээр өвчлөл нь агаарт байгаа хорт утаанд агуулагдах диоксин, кадми, хлор, бензопирин зэрэг хорт бодисын нөлөөгөөр үүсдэгийг олон орны судлаачид тогтоочихсон байна. Тэгвэл утаа хаанаас үүдэж бий болоод байна вэ гэхээр  Улаанбаатар хотын иргэдийн 60 хувь нь амьдарч байгаа гэр хорооллоос. Учир нь гэр хорооллын иргэдийн дулаан хангамжаа шийдэж байгаа нүүрс нь шаталт өндөртэй энерги дулааныг ихээр ялгаруулдаг ч агаарт хамгийн их утаа болон хорт бодисыг ялгаруулдаг гэдэг нь нэгэнт тогтоогдоод байгаа. Мэдээж дан ганц гэр хорооллын утаагаар зогсохгүй Улаанбаатар хотод түгжирлийг жинхэнэ утгаар нь үүсгэх болоод байгаа автомашинууд болоод цахилгаан станцууд тодорхой хэмжээгээр хувь нэмрээ оруулж байгааг үгүй гэх аргагүй зүйл. Учир нь манай цахилгаан станцууд ч гэр хорооллын иргэдтэй адил нөгөө л чулуун нүүрсээрээ л адилхан халаалтаа зохицуулдаг болоод тэр. Уг нь дэлхийн өндөр хөгжилтэй орнууд түлшнийхээ асуудлыг хор ялгаралт багатай хэрнээ дулаан энерги ихтэй түлшийг гарган авч асуудлыг аль болох боломжит хувилбараар шийдвэрлэж чадсан туршлагууд олон байгаа. Харин манай улсын үе үеийн төр засаг энэ тал дээр тийм ч сайн ажиллаж чадахгүй байсаар л, бид хордсоор л. Төрийн өндөр дээд эрхмүүд иргэдийнхээ болон өөрсдийнхөө, үр хүүхдийнхээ эрүүл мэндэд санаа зовдог л юм бол утааг ядаж гамшгийн хэмжээнээс бууруулах арга олох хэрэгтэй байна. Утааг хамгийн ихээр үйлдвэрлээд байгаа гэр хорооллын иргэдийн цахилгааны шөнийн тарифыг яагаад тэглэж болохгүй гэж. Хэрвээ ингэж чадвал айл өрхүүд халаалтаа цахилгаанаар шийдэж, хорт утаа мэдэгдэхүйц багасах нь ойлгомжтой. Тэртээ тэргүй утаатай тэмцэж байгаа нь энэ гээд хэдэн арван тэрбумаар нь зарцуулдаг. Утаанд хордоод өвчилсөн иргэдээ эмчилж байгаа нь гээд мөн л тэрбум тэрбумаар нь мөнгө цацдаг нь үнэн юм чинь. Хэнд ч хэрэггүй зүйлд мөнгөө дэмий цацаж байхаар зөв зүйлд зарцуулж, утаагаа багасгах хэрэгтэй байна. Онилж буй байгаа оноож буудаач эрхмүүд ээ.

ҮЗЭЛ БОДОЛ

# ХЭН ЮУ ХЭЛЭВ







**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Энэхүү хуулийн төслийг УИХ-ын гишүүн С.Чинзориг санаачилсан юм. Тэрбээр “Хууль санаачлах эрхийнхээ дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Малчид болоод хувиараа хөдөлмөр эрхлэгчийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай гэсэн хоёр хуулийн төсөл боловсруулаад, Засгийн газраас санал аваад УИХ-д өргөн барьсан. Эдгээр хуулийн төсөл байнгын хороогоор, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэхийг нь дэмжээд байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслөөр дөрвөн багц асуудлыг шийдвэрлэхээр тооцож байгаа. Даатгалд хамрагдсан хэлбэрээсээ хамаараад, хүүхэд асарсныхаа тэтгэмжийг авч байгаа ээжүүд ялгавартай тэтгэмж авдаг хуулийн зохицуулалт одоо үйлчилж байгаа. Өөрөөр хэлбэл, заавал даатгалд хамрагдсан ээжүүд хүүхдээ асарсных тэтгэмжийг цалингаасаа 100 хувь авдаг. Харин сайн дураараа даатгалд хамрагдсан ээжүүд цалингаасаа 75 хувь авдаг. Тиймээс нэгэнт хүүхэд төрүүлээд, асарсныхаа тэтгэмжийг авч байгаа ээжүүдэд даатгалд хэрхэн хамрагдсан гэх хэлбэрээсээ үл хамаараад 100 хувь тэтгэмжээ авдаг болох нь зүйтэй гэсэн зохицуулалт оруулж өгсөн. Хүүхэд төрүүлээд, хүүхдээ гурван нас хүртэл нь буюу цэцэрлэгт хамрагдах хүртэл нь ээжүүд гэртээ хардаг. Гэтэл энэ хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлт нь тасалддаг. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа ээжүүдийн тэтгэмжтэй байх хугацааны буюу найман сарын шимтгэл төлөгдөөд, үлдсэн нь тасардаг. Үүнээс болж үлдсэн хоёр жилийн шимтгэл тасарч ээжүүд хохирч байна. Тиймээс энэ нөхцөл байдлыг харгалзаж үзээд, хүүхдээ гурван нас хүртэл нь асарч байгаа ээжүүдийн нийгмийн даатгалын шимтгэл, улсад ажилласан жил тасалдахгүй байхаар тусгасан. Түүнчлэн ээжүүдтэй холбоотой өөр нэг зохицуулалт нь олон хүүхэд төрүүлж, өсгөсөн ээжүүдийн хөдөлмөрийг бодитойгоор үнэлэх асуудал юм. Одоо үйлчилж байгаа хуулиар дөрөв буюу түүнээс дээш хүүхэд төрүүлж, өсгөсөн ээжүүдийг 50 настай тэтгэвэрт гарахыг нь зөвшөөрдөг. Энэ бол ээжүүдийн нийгмийн хамгааллыг шийдсэн чухал хууль. Гэхдээ ээжүүд 50 настай тэтгэвэрт гарчихаар ажилласан жил нь бага тооцогдоод тэтгэвэрт гарахдаа бага тэтгэвэр тогтоолгодог дутагдалтай тал бий. Тиймээс олон хүүхэд төрүүлж, өсгөсөн ээжийн хүүхдийнх нь тоогоор улсад ажилласан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн жилийг нь 1.5 жилээр нэмэгдүүлэн тооцож байхаар зохицуулсан. Өөрөөр хэлбэл, дөрвөн хүүхэд төрүүлж, өсгөсөн ээжид улсад ажилласан нийгмийн даатгал төлсөн жил дээр нь зургаан жил нэмэгдээд, тухайн ээж тэтгэвэрт гарахдаа тэтгэврээ өндөр тогтоолгох боломжийг бүрдүүлж өгч байгаа гэсэн үг” хэмээн хуулийн төслөө тайлбарлажээ.

## Г.Өнөрбаяр: Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдэд 11, 12 сард 1.7 тэрбум төгрөг олгоно

*/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн дарга/*

УИХ-ын дахь Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаан болж, Хүүхэд харах үйлчилгээний талаархи асуудлыг хэлэлцсэн. Чуулганы хуралдаанаар ч энэхүү асуудлыг хэлэлцэн төсвийн санхүүжилтэд 5.8 тэрбум төгрөг нэмсэн юм. Энэ талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр мэдээлэл хийсэн. Энэ үеэрээ тэрбээр “Хүүхэд харах үйлчилгээний хууль энэ оны нэгдүгээр сараас хэрэгжиж эхлэх байсан. Гэвч хугацаа нь хойшилж, дөрөвдүгээр сараас хэрэгжиж эхэлсэн. Тэгвэл манай яамны зүгээс ажлын хэсэг гаргаж, Хүүхэд харах үйлчилгээ эрхэлж байгаа газруудыг шалгасан. Одоогийн байдлаар 2557 иргэнд хүүхэд харах үйлчилгээ эрхлэх гэрчилгээ олгосон. Үүнээс 1206 нь энэ чиглэлээрээ үйл ажиллагаа явуулж байна. Улсын хэмжээнд 6553 хүүхэд энэ үйлчилгээнд хамрагдаж байгаа. Мөн улсын хэмжээнд 875 Хүүхэд харах үйлчилгээний газар ажиллаж байна. Энэ онд Хүүхэд харах үйлчилгээнд 10328 хүүхэд хамрагдана гэж тооцоол улсын төсөвт 10.6 тэрбум төгрөг суулгасан. Гэвч Хүүхэд харах үйлчилгээ удааширч, дөрөвдүгээр сараас эхэлсэн учраас төсвийн тодотголоор 5.5 тэрбум төгрөг нь хасагдсан. Харин өнгөрсөн 9, 10 дугаар сарын санхүүжилтэд 2.8 тэрбум төгрөг олгосон. Тэгвэл 11, 12 дугаар сарын санхүүжилтэд 1.7 тэрбум төгрөг олгоно гэж тооцсон байгаа. Улсын хэмжээнд 1206 Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч байгаагийн 609 нь нийслэлд байна. 6553 хүүхдийн 3000 орчим нь нийслэлд байгаа юм. Ерөнхий мэдээлэл өгөхөд ийм байна” хэмээн мэдээлэл өгсөн юм.

...Манай Засгийн газар унасан гол шалтгаан хоёр жил болсны дараа улам тод харагдаж байгаа. Би Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд Монголдоо, ард түмэндээ ашиггүй олон үйлдлийг хийхгүй гэж эсэргүүцсэн...

## Н.Алтанхуяг: Зүгээр хараад сууж чадахгүй болохоор Ерөнхийлөгчид нэр дэвшихээр шийдсэн

*/Монгол Улсын Ерөнхий сайд асан/*

Монгол Улсын Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг мэдэгдэл хийж,2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшинэ гэдгээ албан ёсоор мэдэгдэв. Тэрбээр “Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшинэ гэдэг бол миний хувь улстөрчийн шийдвэр. Би Ерөнхий сайд хийж байсан хүний хувьд Монголын нийгмийн өнөөдрийн байдлыг, манай Засгийн газраас хойших үйл ажиллагааг хараад зүгээр сууж, тэвчиж чадахгүй боллоо. Би Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшинэ гэж бодоогүй байсан. Улс орны нөхцөл, дураараа авирлаж байгаа үйл ажиллагаа, хууль ёсыг гажуудуулдаг, бизнесийг дарамталдаг байдлыг хараад сууж чадахгүй. УИХ-д байхдаа би үгээ хэлж, тэмцдэг байсан. Эд бохир аргаар манай Засгийн газрыг унагаасан. Манай Засгийн газар унасан гол шалтгаан хоёр жил болсны дараа улам тод харагдаж байгаа. Би Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд Монголдоо, ард түмэндээ ашиггүй олон үйлдлийг хийхгүй гэж эсэргүүцсэн. Тэглээ гэж манай Засгийн газрыг огцруулсан. Тиймээс АН шинэчлэгдэж, өөрчлөгдөх ёстой. Гэхдээ АН-ын, ардчиллын гол тулгуурыг хэн ингэж нурааж хаяв гэдгийг гаргаж, ойлголцох ёстой. Тэр чиглэлээр манай намынхан ажиллаж байх шиг байна. Дүрэм, дарга хоёрыг өөрчилсөнөөр намаа шинэчиллээ гэж ойлгож болохгүй. Энэ намыг өөрийн гэсэн толгой, үзэл бодолтой, хэн нэгний утсан хүүхэлдэй болдоггүй хүмүүс гарч ирж удирдана гэдэгт би эргэлзэхгүй байна. Өөрийн гэсэн толгой, үзэл баримтлалтай хүмүүс байх ёстой. Хэн нэгний утсан хүүхэлдэй АН-ын дарга байж болохгүй” хэмээн байр сууриа илэрхийлсэн юм.

# ДЭЛХИЙ

# АМЕРИКЧУУД ЭСЭРГҮҮЦЛИЙН ЖАГСААЛД ШИЛЖЛЭЭ

Б.ДАВАА




АНУ-ын шинэхэн Ерөнхийлөгч ирэх оны нэгдүгээр сарын 20-нд тангарагаа өргөж үүрэгт ажилдаа орох учиртай. Жил гаруй хугацааны турш олон улсын анхаарлын төвд байсан тус улсын төрийн тэргүүнийг сонгох сонгуулийн дүн гарч, үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп Нэгдсэн улсын 45 дахь Ерөнхийлөгч болох нь нэгэнт тодорхой болсон билээ. Түүний хүчтэй өрсөлдөгч, урьдчилсан санал асуулга бүрт Трампыг хол хаяж байсан Ардчилсан намын нэр дэвшигч Хиллари Клинтон харин улс төрийн туршлагагүй ч, тэрбум ам.доллароор тоологдох хөрөнгөтэй тэрхүү эрхэмд ялагдсан. Ерөнхийлөгч Б.Обамагаас эхлээд эдийн засагчид,хэвлэлмэдээллийнхэн “Доналд Трампыг Нэгдсэн улсын Ерөнхийлөгч болоход тохиромжгүй хүн” хэмээн дүгнэж байлаа. Тэдний таамаг ёсоор болсон бол Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон эдүгээ ялалтаа зарлаж байх байлаа. Ерөнхийдөө, Доналд Трампын ялалт урьдчилан тооцоогүй үр дүн байсан гэж хэлэхэд хэтийдсэн болохгүй. Гэвч, Б.Обама улс орны Ерөнхийлөгчийн хувиар халааг нь авахаар хууль ёсны сонгуулиар сонгогдсон дараагийн төрийн тэргүүнийг хүндэтгэн, төрийн эрхийг тайвнаар шилжүүлэх бэлтгэлээ хангахын тулд Цагаан ордонд гэр бүлийнх нь хамт урьсан бол хэдэн сарын турш ширүүн тэмцэлдсэн Хиллари Клинтон ч тайвнаар ялагдлаа хүлээн зөвшөөрч, түүн рүү өөрөө утасдан баяр хүргэж, сонгуулийн үеэр хоёр хэсэгт хуваагдсан ард иргэдээ нэгтгэхийг захисан байна. Харин тэдэнтэй ижил Трампыг дэлхийн хүчирхэг гүрнийг тодорхойлоход тэнцэхгүй гэх бодолтой жирийн иргэд АН-ын лидерүүд шиг хууль ёсны сонгуулийн үр дүнг хүндэтгэхийг хүссэнгүй. Сонгуулийн дүн гарснаас хойш ердөө хэдхэн цагийн дараа сая сая иргэд тэмцлийн хэлбэрт шилжиж , Нэгдсэн улс даяар эсэргүүцлийн жагсаал цуглаан зохион байгуулагдлаа. Лос-Анжелес хотоос эхлээд Бостон хүртэлх олон хотуудад эсэргүүцлийн жагсаал зохион байгуулагдаж буй бөгөөд үл хөдлөх хөрөнгийн бизнесмэн эрийн эзэмшлийн “Трамп тауэр”-ын гадна ч жагсаал цуглаан зохион байгуулагджээ. Жагсагчид “Тэр миний Ерөнхийлөгч биш” хэмээн хашгирч, уриа лоозон барин зогсч байна. Тэр бүү хэл, АНУ-ын бүх цаг үеийн түүхэн дэх хамгийн хөгшин Ерөнхийлөгч гэгдэж буй Доналд Трампын төрөлх хотод ч мянга мянган иргэд жагсаал хийж байна. Тэдний зарим нь “Иргэний эрхийн төлөө дахин тэмцэх ёстой болсондоо итгэж чадахгүй байна” гэж байгаа бол зарим нь “Улс орон маань урагшлан хөгжиж байна гэж бодтол хэдэн ч алхмаар хойшоо ухарчихлаа. Үнэхээр уур хүрч байна” гэж ярьж байна. Тэдний нөгөө хэсэг нь “Трамп л биш”, “Би айдастай амьдармаагүй байна”, “Үзэн ядалт ялах ёсгүй” гэж хэлж байна.

Цагаан ордны гадна ч эсэргүүцлийн цуглаан болсон бөгөөд энэ үеэр Трамп болон Хилларигийн дэмжигчид хоорондоо гар зөрүүлсэн явдал ч гарсан юм. Ийнхүү сонгуулийн дүнд балмагдаж гайхсан, үл хүлээн зөвшөөрсөн иргэд эсэргүүцлээ илэрхийлсээр байна. Вашингтонд ч олон мянган хүн цуглан эсэргүүцлээ илэрхийлсний ихэнх нь залуус, өнгөт арьстнууд байжээ. Тэдний хувьд “АНУ-д фашизм хэрэггүй” гэх мэт уриа лоозонг барин хотын төвөөр жагссан байна. Жагсаалд оролцсон бэлгийн цөөнхийн төлөөлөгч болсон нэгэн эмэгтэй “Бэлгийн цөөнхийнхний эсрэг хатуу бодлого баримталж буй нь буруу. Бид тийм улс болохыг хүсэхгүй байна. Ижил хүйстний гэрлэлтийг хориглох вий гэдгээс би маш их айж байна. Тиймээс өнөөдөр найзуудтайгаа улсаасаа явах талаар хүртэл ярилцаж байлаа” гэжээ. Харин өөр нэг өнгөт арьст залуу “Эмэгтэйчүүд болон үндэсний цөөнх болох Африк гаралтай америкчуудыг албадан гаргах вий гэдгээс үнэхээр их айж байна” гэж ярьжээ. Энэ мэтээр Америкчууд шинэ төрийн тэргүүнээсээ айж буй сэтгэгдлээ илэрхийлэн жагсаж, зарим нь бүр Канад, Шинэ Зеланд руу нүүх бэлтгэлээ хангах болсон гэнэ. Үүнээс гадна АНУ-ын Сиэтл хотод болсон мөн эсэргүүцлийн жагсаалаар буун дуу гарч, таван хүн шархадсан байх бөгөөд тэдний хоёрынх нь биеийн байдал тун хүнд байгаа ажээ. Одоогоор хэргийг цагдаагийн байгууллага шалгаж байна. Нэгдсэн улсад иймхэрэг мандаж байхад, ОХУ, БНАСАУ энэ удаагийн сонгуулийн дүнг боломж гэж харж байгаа юм. Сонгуулийн дүн гарсны дараа Оросууд тус улсын эсрэг тавьсан эдийн засгийн хориг цуцлагдана хэмээн баярлаж, В.Путин хүртэл Трампад баярын цахилгаан илгээж хамтран ажиллахаа илэрхийлсэн. Харин БНАСАУ эдүгээ хүртэл АНУ-ын улс төрийн бодлогын гол чиглэл байсан цөмийн зэвсгийг халах бодлогыг “Үеэ өнгөрөөсөн уран зөгнөл” хэмээн мэдэгдэж, даруй цуцлахыг Трампад сануулжээ. Эмэгтэйчүүдийг зүй бус үгээр гутаан доромжилж байсан тэрбумтан эр Ерөнхийлөгч болсонд урлаг соёлын зарим алдартнууд ч тун эмзэг хандаж буй. Тухайлбал, сонгуулийн урьдчилсан дүнгээр Трамп тэргүүлж эхэлмэгц дуучин Лэди Гага уйлсан бол жүжигчин Деми Ловато твиттертээ бухимдлаа илэрхийлэв.

## “Афган охин”-ыг Пакистанаас албадан гаргажээ

АНУ-ын “National Geographic” сэтгүүлийн нүүрт нийтлэгдэж, дэлхий дахинаа алдаршсан “Афган охин” алдарт зурагны эзэн болох эмэгтэй Пакистаны Пешавар хотод хуурамч бичиг баримттай явж байгаад баривчлагдсан талаар бид өмнө нь мэдээлсэн. Тэгвэл Шарбат Гула гэгчийг Пакистаны эрх баригчид улсаасаа албадан гаргахаар болжээ. “National Geographic” сэтгүүлийн гэрэл зурагчин Стив МакКарри 1984 онд Пакистаны дүрвэгсдийн лагерьт зураг авч явахдаа 12 настай Шарбат Гула гэх охины зургийг авсан байдаг. Улмаар түүний авсан зураг сэтгүүлийн нүүрт нийтлэгдсэнээр дэлхийн хамгийн алдартай зураг болж чадсан юм.Албаны эх сурвалжийн мэдээлснээр Шарбат Гула 2014 оны дөрөвдүгээр сард Пешавар мужид Шарбат Биби гэх нэрээр Пакистаны биеийн байцаалт авсан байсан аж. Гэвч, Пакистаны цахимд шилжүүлсэн бүртгэлийн системд Шарбат Гулатай яг ижил биеийн байцаалт авсан Афганистаны дүрвэгсэд хэдэн мянгад хүрчээ. Шарбат Гула эмнэлэгт 15 хоногт хоригдохдоо гепатит С вирусийн эмчилгээ хийлгэсэн байна. Түүнийг дөрвөн хүүхдийнх нь хамт хил дээр хүргэсэн бөгөөд дараа нь тэрбээр Афганистаны Ерөнхийлөгч Ашраф Ганитай уулзжээ. Тэрбээр өнгөрсөн сарын 23-нд Пешавар хотод баривчлагдаж, гэм буруутай болох нь тогтоогдсон бөгөөд 110 мянган рупигийн торгууль хүлээсэн байна. Тэрбээр хорих ялаар шийтгүүлж магадгүй байсан юм.

# №3 НИЙГМИЙН ДААТГАЛЫГ УЛСААС ХЭРЭГЖҮҮЛЭХИЙН УЧИР

*Манай сонин долоо хоног бүрийн баасан гарагт нийгмийн даатгалын үйлчилгээ, түүний талаархи түгээмэл асуулт хариултын буланг Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын Монгол Улсад хэрэгжүүлж буй Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн мэргэжилтнүүдтэй хамтран бэлтгэн хүргэж байгаа билээ. Уншигчдын төдийлөн мэддэггүй ч, заавал мэдэж байх ёстой түгээмэл асуултад Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн ахлах зөвлөх Ямашита Маморү хариулж байна.*

### Хувийн ба улсын даатгалын ү/а-ны ялгаа

| Хувийн даатгал | Улсын нийгмийн даатгал |
|---|---|
| ▪ Шимтгэл төлөх даатгуулагчийн хэрэгцээнд тохирсон олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг. | ▪ Нэгэн хэвийн даатгалын үйлчилгээ үзүүлэх хандлагатай. |
| ▪ Улсын нийгмийн даатгалын үйлчилгээнд байдаггүй олон төрлийн эрсдлээс сэргийлсэн даатгал байдаг. | ▪ Нийт иргэдийг даатгалд хамрагдах боломжоор хангасан. |
| ▪ Өвчлөмтгий, орлого багатай иргэд даатгалд хамрагдах боломж муутай. | ▪ Орлогын түвшингээс хамаарч, шимтгэлийг хэмжээг өөрчлөх боломжтой. |

**-Хувийн даатгалын компани иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд хангалттай гэж бодож байна. Яагаад заавал улс даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёстой юм бэ?**

-Хувийн компаниудын үзүүлдэг даатгалын үйлчилгээнд хязгаар бий. Даатгал гэдэг нь нийт ард иргэд нэгдсэн дүрмийн дор шимтгэл төлж, тусламж хэрэгтэй хэн нэгэн даатгуулагчид журмын дагуу дэмжлэг үзүүлдэг тогтолцоо юм. Жишээлбэл, автомашины ослоор бэртэл авсан бол 500 мянган төгрөг олгоно гэсэн дүрмийн дор 100 хүн тус бүр 10000 төгрөг гаргана гэж үзье. Тэдгээр хүмүүсийн ихэнх нь залуучуудаас, эсвэл 40-с дээш насныханаас бүрдэж байвал та аль бүлэгт нь орох вэ. Төлөх шимтгэлийн хэмжээг багаар тогтоож, эрсдэлд орох магадлал багатай эрүүл, залуу хүмүүсийг даатгалд хамруулах сонирхол давамгайлаад ирэхээр эрсдэл өндөртэй иргэд даатгалд хамрагдаж чадахгүйд хүрнэ. Үүнээс сэргийлэхийн тулд улсаас нийт ард иргэдээ албан журмаар нэгдсэн бүлэгт оруулдаг тогтолцоог нийгмийн даатгал гэдэг юм. Энэ том бүлэгт тухайн улсын нийт иргэд хамрагдсанаар эрсдэлийг их, бага гэж ялгаварлах шаардлагагүй болно. Ийнхүү төрөөс нийгмийн даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлснээр өвчтэй, бага орлоготой иргэд ч нийгмийн хамгаалалд багтах боломж бүрддэг.

# Бүх дэлхийг аажмаар хамарч байгаа дэлхийн эдийн засаг санхүүгийн хямралтай хэрхэн, ямар аргаар бид тэмцэх вэ

Ж.ХИШИГЖАРГАЛ

Бүгд найрамдах Казахстан улсын лидер Нурсултан Назарбаев энэ асуултын хариу болгож “Эхлээд эдийн засаг, дараа нь улс төр” гэсэн өөрийн төлөвлөгөөг санал болгожээ. Түүний бодлоор бүх улсын хувьд хамгийн хүчтэй нэгтгэх хэрэгсэл бол валют. Нэгдсэн, үндэсний, улс төрийн хүчин зүйлүүдээс хамаардаггүй валют. Тэрээр дэлхийн нэгдсэн валютыг бий болгох талаар нэлээн хэдэн жил илтгэл тавиад байгаа. Үүний нэг жишээ нь долоон жилийн өмнө Дели хотод /Энэтхэг/ болсон бизнес-форум дээр хийсэн ноён Назарбаевын илтгэл юм. Дэлхийн эдийн засгийн хямралаас гаргах хэрэгслийн үүргээр дэлхийн үндэсний валютын системийг байгуулахыг санал болгосон. Ялангуяа хамгийн өргөн хүрээтэй, ямар сөрөг нөлөөгүй систем. Тэрбээр ирээдүйн арга хэмжээний үр дүн бол одоогийн байгаа шиг ганцхан үнэт цаас гаргагчтай, ардчилсан бус, чөлөөт биш, өрсөлдөөнгүй, хянах боломжгүй дэлхийн систем биш шударга дэлхийн валютын системийг байгуулах нь юм гэж үзжээ. Үүний зэрэгцээ дэлхийн орнууд НҮБ-ээр хүлээн зөвшөөрөгдсөн, зохих комиссоор шалгагддаг бараа солилцох дэлхийн ашигтай мөнгөний нэгжийг бий болгох талаар тохиролцох хэрэгтэйг тэрээр дурдсан байна. Түүний үгээр бол энэхүү механизм нь практик дээр хэрэгжих бүрэн боломжтой. НҮБ-аар сонгогдохоос гадна нэгдсэн валютын систем нь дэлхийн улсуудын ихэнх нь гарын үсэг зурсан “Дэлхийн валютын тухай” хуулиар батлагдсан байх ёстой аж. Энэхүү зах зээл дээр дэлхийн валют гаргагч хэсэг бүлгүүдийн давуу эрх хамаарахгүй ба энэхүү систем нь хүн төрөлхтөний түүхэн дэх анхны хууль ёсны дэлхийн валютын системийн үндэс болж чадна. Олон улсын давуу эрхтэй, бэлэн бус, тогтвортой гэсэн нөхцлүүд нь мөнгөний нэгжийн зайлшгүй нөхцлүүд болох ёстой ба түүний ханш нь дэлхийн валютын хэлбэлзлээс хамаардагггүй байх юм. Шинэ валютын систем нь аль хэдийн бүрэлдсэн одоогийн системийг эвдэлгүй, тогтвортой, удаан хугацааны дэд бүтцийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны урсгал гүйлгээг явуулахад дэм болно гэж Назарбаев баталж байна. НҮБ-ийн 100 жилийн ойд зориулан “2045 дэлхийн стратегийн санаачлага”-ыг боловсруулж, одоогийн олон улсын механизмыг сайжруулж, шинэ системийг бий болгож, түүнийг орчин үеийн нөхцөлд бодитоогоор ажилладаг болгох хэрэгтэй гэж тэрээр үзэж байгаа. Энэ симтемд нэгдсэн валют нь нэлээд их үүрэг гүйцэтгэж байгаа. Назарбаев НҮБ-ийн эдийн засаг, нийгмийн зөвлөлийг Дэлхийн хөгжлийн зөвлөл болгон өөрчлөн, НҮБ-ийн Ерөнхий Ассамблейгээр сонгогдсон гишүүн орнуудаас гадна НҮБ-ийн тусгай байгууллагуудын удирдлагууд, ялангуяа Олон улсын валютын фондыг оруулж зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөжүүлэхийг санал болгожээ. Энэхүү байгууллага нь дэлхийн эдийн засгийн зохицуулагчийн функцийг гүйцэтгэх ба түүнд эдийн эдийн засгийн өсөлтийн тулах цэг гэж тооцогддог дэлхийн төслүүдийг хэрэгжүүлэх үүрэг ногдож байгаа. Энэ нь дэлхийн хямралын эрсдэлийн мэдэгдэхүйц бууруулж, үндэсний эдийн засаг, нийгмийн бодлогын асуудлаар улс орнуудын хариуцлагатай байдлыг хангахад тус болно. Мөн дэлхийн хэлэлцээрийн чухал асуудлууд болох терроризм, улс орны задрал, шилжилт хөдөлгөөн зэрэг бусад сөрөг үйл явдлуудыг шийдэхэд тус нэмэр болно. Эдгээрийг Назарбаев нь эдийн засгийн хямрал, ядуурал, бичиг үсэггүй байдал, ажилгүйдлийн үр дүн гэж тооцон үүнтэй эдийн засгийн аргаар тэмцэх нь зүйтэй гэж үзэж байна. Дэлхийн хэмжээний хямралын эсрэг идэвхтэй тэмцлийг өрнүүлэхийн өмнө НҮБ-ийн гишүүн-орнууд санхүүгийн системээ хэвийн байдалд оруулах нь зүйтэй. 20-р зуунд шинэ төрлийн санхүүгийн хэрэгсэл дэлхийд хэрэгтэй байна гэж тэрээр онцлон дүгнээд тогтвортой хөгжил цэцэглэлийн зорилго, бодлогод нийцсэн дэлхийн үндэсний валютыг боловсруулах талаар НҮБ-ийн гишүүн орнууд хүчээ нэгтгэх хэрэгтэйг уриаллаа.

Назарбаевын энэ санал бусад хүмүүсээс өөрийн үнэлэмжийг аваад байгаа. Эдийн засгийн ухааны Нобелийн шагналт, шинжээч, нэрт эрдэмтэн Роберт Манделл: энэ төсөл нь практикт хэрэгжүүлэхэд хэцүү ч анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзжээ.

Тэрээр “ Би Ерөнхийлөгч Назарбаевын гаргасан саналтай нэгдэж буйгаа мэдэгдээд, тэр маш зөв замаар явж байна. Дэлхийн валютын удирдлагын зарчмын хувьд бол олон төрлийн арга, систем байдаг. Жишээлэхэд бүсчлэлийн систем гэж байгаа, Европд өөрийн валютыг, мөн азийн валют, африкийн валютыг бий болгож болно. Хэрвээ дэлхийн арга хэмжээ нь зохимжгүй бол энэ аргыг хэрэглэж болно” гэжээ. Мөн эдийн засгийн ухааны Нобелийн шагналт Эдмунд Фелпс Назарбаевын саналтай бүх талаар нийцээгүй ч түүний саналыг онцлон үзсэн юм. Шинэ дэлхийн валютыг бий болгох процесс нь өөрөө маш нарийн арга ажиллагааг шаардана. Шинэ валютыг тогтвортой байлгах механизмыг бодож олох хэрэгтэй гэжээ.

MMINFO.

# СПОРТ



М.ШИЙРЭВЖАМЦ: ӨВӨӨ, ААВ ХОЁРЫНХОО МӨРӨӨДЛИЙГ БИЕЛҮҮЛСЭНДЭЭ БАЯРТАЙ БАЙНА
VI нүүрт

Ж.НАРАНТУНГАЛАГ ӨНӨӨДӨР МАРАТ ГАФУРОВААС ДААГАА НЭХНЭ
VIII нүүрт



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# Л.ЦЭНД:
## БИДЭНД СЭТГЭЛЭЭСЭЭ АЖИЛЛАХ ДАСГАЛЖУУЛАГЧ ХЭРЭГТЭЙ БАЙСАН, ТЭГЭЭД Д.ЭНХБАЯРЫГ АМЕРИКААС ДУУДАЖ БАЙЛАА

Н.ПУНЦАГБОЛД

*Монгол Улсын тэшүүрийн спортын ууган Гавьяат тамирчин ,спортын мастер, дасгалжуулагч Л.Цэнд багштай ярилцлаа.*

**-Монгол Улсад өвлийн спорт сайн хөгжөөгүй байна. Гэхдээ тэшүүрийн спортын үе үеийн тамирчид бахдам амжилтыг гаргасаар ирсэн. Хамгийн сүүлд гэхэд Монголоос тэшүүрийн спортын төрлөөр Залуучуудын Олимпийн аварга төрлөө. Тэгвэл одоо энэ спортын хөгжил ямар төвшинд байна гэж та хардаг вэ?**

-Энэасуудлыгярихаарулсынхөгжилтэй холбох л болно. Одоо бид шинжлэх ухаан, техникийн эрин үед амьдарч байна. Манай улсаас бусад бүх оронд битүү гулгуурын талбайтай болчихсон. Манайхтай адил хогийн шүүр бариад мөсөн дээр зогсдог улс гэж дэлхийд байхгүй. Дээр үед, намайг уралдаж байхад бол яах вэ, манайхтай адил улсууд байсан. Одоо тиймгүй шүү дээ. Бүр ганц ч биш өч төчнөөн битүү дээвэртэй өвлийн спортын ордонтой байна. Японд маш олон битүү гулгуурын талбай байгаа. Битүү гулгуурын талбайтай учраас л тамирчдын ур чадвар эрс өсч байгаа юм. Бид жилдээ хоёр сар орчим л гулгадаг. Гэтэл гадаадын тамирчид жилийн есөн сард нь гулгаж байна. Бусад нь үед амраад, бие бялдраа хөгжүүлэх дасгал хийж байгаа. Ингээд л дэлхийн улс орнуудын тамирчдын ур чадвар эрс дээшилчихлээ. Манай улсын хувьд 10-аад жилийн өмнө битүү гулгуурын талбай барья гэж яриад, Дэлхийн Тэшүүрийн холбооны Ерөнхийлөгч хүртэл Монголд ирсэн шүү дээ. Тухайн үеийн Ерөнхий сайд уулзаад, битүү гулгуурын талбай байгуулах Засгийн газрын тогтоол гарсан. Гэвч өнөөдрийг хүртэл 10 жил хөөцөлдөөд барьж чадаагүй л явна. Үүгээрээ л бид хоцорч байна. Уг нь 10 жилийн өмнө шийдсэн асуудлыг 5-6 жил яриад, барьвал барьчихмаар юм даа. Даанч барих сэтгэл дутсан байх. Дээрээс нь мөнгө төгрөг дутсан, газар нь олдоогүй гээд тоочвол олон юм байна даа. Би хувьдаа битүү дээвэртэй ордонтой болчих юмсан гэж их зүтгэсэн. Багш нь 75 хүртлээ гадаа хүйтэнд зогссон. Өвлийн хүйтэнд гадаа зогсоно гэдэг тийм амар биш шүү. Тийм болохоор битүү ордонтой болох гэж их үзлээ. Даанч бүтээгүй л байна. Тиймдээ ч тэшүүрийн хөгжил манайд тийм ч сайнгүй байна. Уг нь гадаа талбай гэхэд л нэлээд олон байсан. Одоо бүгд байхгүй болчихлоо.

**-Манай тамирчид бэлтгэлээ дугуйт тэшүүрээр хангаж байгаа талаар яриад байдаг. Тэгж бэлтгэл хийгээд гадаадын тамирчидтай өрсөлдөх боломж бага биз дээ?**

-Дугуйт тэшүүрээр бэлтгэл хийх нь хэрэгтэй. Америк, Солонгосын тамирчид дугуйт тэшүүрээр уралддаг. Гэхдээ зүгээр машин явдаг засмал зам дээр бэлтгэл хийхээр болохгүй шүү дээ. Бас л зориулалтын талбай байх ёстой юм. Тэгж байж л амжилт гаргана.

Үргэлжлэл нь VII нүүрт

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Ерөнхийлөгчийн тамгын газрын нэрэмжит хөлбөмбөгийн тэмцээн маргааш эхэлнэ

Ерөнхийлөгчийн Тамгын газрын нэрэмжит цомын төлөөх танхимын хөлбөмбөгийн тэмцээнийг өнгөрсөн 2015 оноос зохион байгуулж эхэлсэн юм билээ. Энэ тэмцээн нь төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдраа хөгжүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой юм. Тэгвэл энэ жилийн тэмцээнийг Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монголын хөлбөмбөгийн холбоотой хамтран ирэх амралтын өдрүүдэд Монголын хөлбөмбөгийн холбооны зааланд зохион байгуулах гэж байна. Тэмцээний нээлтийн үйл ажиллагаа маргааш өдрийн 13:00 цагаас болно. Нээлтийн үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ц.Баяр-сайхан, Ерөнхийлөгчийн зөвлөх, Монголын хөлбөмбөгийн холбооны Ерөнхийлөгч А.Ганбаатар нарын зэрэг хүмүүс оролцох юм байна. Харин тэмцээнд Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон бүх яамдын баг оролцох ажээ.

## Монголын хөлбөмбөгийн шигшээ тэмцээнээ өндөрлүүллээ

Малайз улсад энэ сарын 2-ны өдөр эхэлсэн “AFC Solidarity 2016” тэмцээний хэсгийн шатны тоглолтууд өнгөрсөн лхагва гарагт өндөрлөлөө. Тэгвэл энэхүү тэмцээний B хэсэгт манай улсын шигшээ баг Макао, Шри Ланк, Лаос гэсэн улсуудтай багтсан. Хэсгийн эхний тоглолтоо Макаотай хийж, илүү тоглолтыг үзүүлсэн боловч харамсалтайгаар эрэг үр дүн авч чадалгүй 2:1-ээр хожигдсон. Гэхдээ дараагийн учраа болох Шри Ланкыг Н.Наранболдын хоёр гоолоор буулгаж авсан билээ. Нөгөө талд Лаос, Макаод 4:1-ээр хожигдсон тул манай баг сүүлийн тоглолтодоо тэнцэхэд л гоолын зөрүүгээр хэсгийн шатыг давах боломжтой болоод байв. Гэвч харамсалтай нь лхагва гарагийн орой хэсгийн гуравдугаар тойргийн тоглолтоо Лаостай хийж, 3:0-ээр хожигдсоноор тэмцээнээ өндөрлүүллээ.

## Чөлөөтийн холбооны Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийг бүртгэж эхэлжээ

Монголын Чөлөөт бөхийн холбоо энэ сарын 19-нд өргөтгөсөн хурлаа хийхээр болсон байна. Тэгвэл тус холбооны Ерөнхийлөгчид өрсөлдөх нэр дэвшигчдийг өчигдрөөс бүртгэж эхэлжээ. Холбооны Ерөнхийлөгчид нэр дэвших хүсэлтэй хүмүүс энэ сарын 16-ны дотор Монголын Чөлөөт бөхийн холбооны цахим шуудангаар хүсэлтээ явуулахаас гадна биечлэн очиж бүртгүүлэх юм байна. Ерөнхийлөгчид нэр дэвшигч нийгэмд тодорхой нэр хүндтэй, чөлөөт бөхийн спортыг хөгжүүлэх эрмэлзэлтэй, гадаад хэлний мэдлэгтэй, санхүүжилттэй холбоотой харилцааг зохицуулах, баг хамт олныг бодлогын түвшинд удирдан зохион байгуулах чадвартай байх ёстой аж. Энэ сарын 19-нд болох өргөтгөсөн хуралд холбооны ерөнхийлөгч, хүндэт ерөнхийлөгч, Удирдах зөвлөл, аймаг хариуцсан Дэд ерөнхийлөгчид, зөвлөлүүдийн гишүүд, холбооны аппарат, Гавьяат дасгалжуулагч, Гавьяат тамирчид төлөөлөгчөөр оролцох аж. Мөн аймаг тус бүрээс нэг төлөөлөгч, Спорт хороод, Нийслэл, дүүргийн спорт хороо, Монголын чөлөөт бөхийн мастеруудын холбоо, Мэргэжлийн сургалттай биеийн тамир, спортын дунд сургууль, чөлөөт бөхийн төрөлжсөн сургалттай сургууль, Биеийн тамирын их дээд сургууль, оюутны шигшээ баг, спорт клуб тус бүрээс нэг хүн төлөөлөгчөөр оролцох юм байна.

## Олимпийн бус жингийн ДАШТ-д зодоглох бөхчүүд тодорлоо



Чөлөөт бөхийн Олимпийн бус жингийн ДАШТ ирэх сард Унгар улсад болох билээ. Тэгвэл энэ тэмцээнд оролцох бөхчүүдийг сонгон шалгаруулах сорилго тэмцээн “Хасу-Мегаватт” компанийн спортын “Эко цогцолбор”-т болж өндөрлөлөө. Сорилго тэмцээнд 2016 оны Бүх ард түмний Спортын наадмын мөнгө, хүрэл медальтнууд, оюутны ДАШТ, Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн, олон улсын тэмцээнээс медаль хүртсэн бөхчүүд оролцсон юм. Тэгвэл Олимпийн бус жингийн ДАШТ-ний эрэгтэйчүүдийн 61 кг-ын жинд “Гацуурт-Олимп” клубын тамирчин Т.Түвшинтулга оролцохоор шалгарлаа. Харин 70 кг-д “Хилчин” спорт хорооны тамирчин Б.Батзориг оролцохоор болсон юм. Эмэгтэйчүүдийн хувьд 55 кг-д “Хасу-Мегастарс” клубын тамирчин Д.Отгонцэцэг оролцох эрхээ авсан бол 60 кг-д Цастын барс” клубын бөх Б.Шоовдор оролцоно.

# СПОРТ





*Үр, хүүхдээ улс орон, нийгэмд хэрэгтэй нэгэн болгож хүмүүжүүлнэ гэдэг энэ хорвоод аав, ээж гэх эрхэм алдрыг хүртсэний учир утга биз ээ. "Монголын мэдээ" сонин энэ удаа даамын спортын төлөө сэтгэл зүрхээ зориулж буй нэгэн гэр бүлд зочилж оюуны спортын талаархи сонирхолтой яриа өрнүүллээ.*

## М.Нямжаргал: Монголчууд Азид даамаар ноёрхдог ч улсын шигшээ баг байдаггүй

*/Азийн хошой аварга, олон улсын их мастер, улсын өсвөр, залуучуудын найман удаагийн аварга тамирчин/*

**-Монголын анхны эмэгтэй Азийн хошой аварга тамирчин боллоо. Ямар амжилт үзүүлж, хошой аваргын болзлоо хангав?**

-Анх Даамын эмэгтэйчүүдийн Азийн аварга шалгаруулах тэмцээн 2010 онд манай улсад зохион байгуулагдсан юм. Тэр үед би 14 настай байсан ч Монгол Улсаа төлөөлж оролцох дөрвөн тамирчны нэгд багтсан. Намайг тоглож эхэлж байх үед даамын спортын тэмцээний насны ангилал нь харилцан адилгүй байсан л даа. Тухайлбал, 16-гаас доош насны хүүхдүүд хоорондоо тоглодог. Тэгэхээр их харьцангуй шүү дээ. Мэдээж найман настай хүүхдээс 16 настай хүүхэд нь илүү сэтгэнэ. Түүнээс болж би насанд хүрэгчидтэй хамт Азийн анхны эмэгтэйчүүдийн даамны аварга шалгаруулах тэмцээнд оролцсон юм. Одоо даамын тэмцээн 8-10, 11-13, 14-16 гэсэн насны ангилалтай болсон. Анхны Азийн авваргаас би хүрэл медаль хүртсэн. Тэгэхдээ өмнө нь ялж чаддаггүй байсан мастеруудаа ялж, хүрэл медалийн болзол хангасан. Би Мандахнаран, Энхзаяа гэдэг мастер эгч нарыг хожиж байгаагүй. Гэтэл тэр тэмцээний үеэр Мандахнаран эгчийг зооноос гарахдаа, Энхзаяа эгчийг хүрэл медалийн төлөө тоглохдоо хожиж, медальт байрт шалгарч байсан юм. Дараа нь 2012 онд Малайз улсад болоход нь дахин оролцож, түрүүлсэн. 2012 оны Даамны эмэгтэйчүүдийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлж, Ази тивийн анхны их мастер цолыг хүртсэн. Маш их баярладаг. Гурван жил Азийн аваргад оролгүй өнжиж байгаад энэ жил оролцоод дахин түрүүлсэн. Тэгээд Азийн хошой аварга болсон. Энэ тэмцээний хамгийн хүчтэй өрсөлдөгчид хятадууд байлаа. 2013, 2014 оны Азийн аварга тамирчидтай өрсөлдсөн. Мөн 2013 оны дэлхийн залуучуудын аварга охин ч байсан. Гэхдээ энэ гурван охин гурвуулаа медаль авч чадаагүй. Эхний гурван байрт Монголын тамирчид орсон. Ер нь Монголчууд Азид даамын спортоороо ноёрхож байна. Мөн насанд хүрэгчдийн Азийн аварга шалгаруулах тэмцээн хоёр жилд нэг удаа болдог учраас тамирчдын дунд хүлээлт ихтэй, том тэмцээнд ордог. Дэлхийн аваргад орох эрхээ азийн аваргийн тэмцээнээс авдаг.

**-Дэлхийн аваргад орох эрхээ олж авсан байна шүү дээ?**

-Тийм. Би дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцохын тулд Азийн аваргад орсон. Дэлхийн аваргын тэмцээн маань ирэх жил Истони улсад болно. Энэ тэмцээн маань 16 эмэгтэй тамирчин тойргийн системээр тоглодог. Тэгэхээр Ази, Европын аваргуудтай өрсөлдөнө.

**-Даам олон төрөл байдаг. Чи аль төрлөөр нь тоглодог вэ?**

-Би оюуны спортын үндсэн төрөл болох 100 буудалт даам тоглодог. Яахав, бусад орны онцлогоос шалтгаалаад олон төрлийн даам бий.

**-Хэдэн настайгаасаа даам тоглох болсон бэ. Даам тоглох болсон түүхээ хуваалцвал?**

-Би зургаан настайгаасаа даамын спортоор хичээллэсэн. Манайх Завхан аймагт амьдардаг байсан юм. Аймгийн спортын их наадам бол миний анхны тэмцээн. Долоон настайдаа тэр наадамд оролцож, өөрөөсөө том хүүхдүүдтэй өрсөлдөн, мөнгөн медаль авч байсан. Тэр үед аав минь надад даам тоглохыг зааж өгсөн. Би аав, ээждээ их баярлаж, бахархаж явдаг. Аав, ээж маань хүүхдүүдээ илүү хөгжүүлэх, даамын спортоор дагнуулахын тулд хот руу нүүх шийдвэрийг гаргасан. Хотод ирээд клубт хамрагдаж, даамын спортоор илүү хичээллэх болсон доо. Миний ээж, аав бидний төлөө маш их зүйлийг хийсэн. Бидний оюунд маш том хөрөнгө оруулалт хийсэн гэж би боддог.

**-Зургаан настайгаасаа хичээллэсэн гэхээр даамын спортын тамирчдын жаргал, зовлонг мэддэг болсон байх. Даамын спортоор хичээллэж байгаа тамирчдад ямар асуудал тулгарч байна. Төрөөс ямар дэмжлэг хэрэгтэй байна вэ?**

-Ер нь тамирчин бүрт л санхүүгийн асуудал тулгардаг л даа. Ямар нэгэн тэмцээн, уралдаанд ороход. Зарим азтай гэх юм уу хөөцөлдөлгөө ихтэй хүмүүс ивээн тэтгэгчтэй байдаг. Би тэр азтай хүмүүсийн нэг. Намайг "Ялгуусан" компанийн захирал Санжаадорж ах таван жил ивээн тэтгэж, тэмцээний зардлыг маань дааж байна. Миний эмзэглэж явдаг нэг зүйл бий. Шатрын спорт улсын шигшээ багтай болчихлоо. Гэтэл адилхан оюуны спорт хэрнээ даамын спортын улсын шигшээ баг байдаггүй. Тиймээс даамын спортын шигшээ багтай болоосой гэж их хүсдэг. Даамын тамирчид шатарчдаас илүү их амжилт гаргаж байна. Даамын спортоос өсвөрийн хоёр дэлхийн аварга төрчихлөө. Мөн Азийн аваргууд их төрж байна. Шатраас дутахааргүй амжилт гаргаж байгаа. Азийн аваргын шатрын тэмцээнээс ганц л медальтай ирсэн. Гэтэл манай даамын тамирчид маш том амжилт үзүүлсэн шүү дээ. Сүүлийн үед даамын спорт Монголд хөгжиж, өндөр амжилт гаргаж байгаа нь их мастеруудтай холбоотой. Их мастерууд өөрсдийн клубтэй болж, хоорондоо их өрсөлдөж, хүүхдүүдээ чадавхжуулж байна. Их мастер Манлай ахын клуб дээр гэхэд л цуврал тэмцээн их болдог. Тоглолдоо насны ангилал хамаарахгүй тоглож байгаа учраас бие биеэсээ туршлага хуримтлуулдаг.

## М.Шийрэвжамц: Өвөө, аав хоёрынхоо мөрөөдлийг биелүүлсэндээ баяртай байна

*/Дэлхийн даамны холбооны мастер, Өсвөрийн дэлхийн аварга, Азийн аварга, Улсын зургаан удаагийн аварга тамирчин/*

**-Юун түрүүнд Даамын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож, дэлхийн аварга болсонд баяр хүргэе. Сэтгэгдлээсээ хуваалцахгүй юу?**

-Олон орны даамын мастеруудтай өрсөлдөж, дэлхийн аварга болсондоо маш их баярлаж байна. Энэ бүхэн бол миний аав, ээж, багш нарын минь ач. Амжилтад хүрэхэд тусалж, дэмжсэн бүх хүмүүст баярлалаа гэж хэлмээр байна.

**-Тэмцээнийхээ талаар танилцуулахгүй юу. Ямар онцлогтой вэ?**

-100 буудалт даамын өсвөр, залуучуудын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн Турк улсын Измир хотод 28 дахь удаагаа боллоо. Энэхүү тэмцээнд нийт 30 орны 218 даамчин ур чадвар, оюун ухаанаараа өрсөлдсөн. Харин манай улсын 24 тамирчин найман насны ангилалд өрсөлдөж, үндсэн төрөлд алт, мөнгө, хүрэл медаль, блиц төрөлд нэг алт, хоёр хүрэл, турк даамын төрөлд таван алт, долоон мөнгө, нэг хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлсэн. Даамын бүх төрөлд бүх насны ангилалд залуучууд болон өвсөрийн тамирчид оюун ухаанаараа өрсөлддөгөөрөө онцлогтой. Дэлхийн аварга учраас ази, европ гэлтгүй бүх улсын тамирчид оролцдог.

**-Дэлхийн аваргад оролцох эрхээ хэрхэн олж авсан бэ?**

-Би дэлхийн аваргын тэмцээнд 11 настайгаасаа оролцож байна. Энэ жилийн дэлхийн аваргын тэмцээнд оролцох эрхээ их сонин олж авсан даа. Учир нь энэ жилийн Даамын өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож, 12 дугаар байрт шалгарч, медаль авч чадаагүй. Үүнээс болж дараа дараагийн тэмцээнд оролцох эрх авах боломжгүй болсон. Хэрвээ өсвөрийн улсын аваргад медальт байрт шалгарсан бол "Азийн хүүхдүүд" наадмын даамын тэмцээнд оролцох байсан юм. Гэвч тэгээгүй.

**-Улсын аваргад түрүүлээгүй болохоор сэтгэл санаагаар унаж байв уу?**

-Үгүй. Аав минь надад нэг зүйлийг их захидаг л даа. Олон сайхан аавын хүүхдүүд дунд миний хүүг хожих хүү байлгүй яах вэ. Сайхан тоглоод л дуусга гэдэг юм. Тиймээс нэг их сэтгэл санаагаар унаад, хожих байсан юм гэж дайраагүй. Улсын аварга шалгаруулах тэмцээн учраас 21 аймаг, дүүргээс шалгарсан шилдэг хүүхдүүд өрсөлддөг. Өнгөрсөн жил гэхэд 94 тамирчин оролцсон. Тухайн үед Пүрэвдорж багш маань сэтгэл зүйн бэлтгэл дутуу байна гэж надад хэлж байсан. Би наймдугаар өрөг дээр хоёр оноогоор түрүүлж явсан ч буруу нүүдэл хийгээд тэнцчихсэн. Дараагийн өрөгтөө тоглохдоо бас хожигдсон. Энэ тэмцээнээс их зүйл сурсан. Харин дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ бүх ард түмний XIV дүгээр наадамд оролцож, хүрэл медаль хүртэж авсан. Гэхдээ тэмцээнд бараг хожигдох байх гэж бодож байсан юм. Учир нь багштайгаа учраа таарсан. Урьд орой нь багшийгаа хожихгүй байх гээд л тайван унтчихсан ч маргааш нь хожчихсон. Өөртөө ч итгээгүй. Тэр тэмцээнээс л дэлхийн аваргад оролцох эрхээ олж авсан даа.

**-Дэлхийн аваргын тэмцээний тоглолтоосоо сонирхуулахгүй юу. Тэр дундаа сүүлийн тоглолт их өрсөлдөөнтэй болсон байх?**

-Би нийт есөн тоглолт хийж, зургаа хожиж, нэг хожигдоод, хоёр тэнцсэн. Зургаа хожихдоо, Голланд, Беларусь, Украйн, Хятад, Истони, Казакстаны тамирчидтай тоглосон. Харин хоёр тэнцэж, нэг хожигдохдоо оросын тамирчидтай таарсан. Ер нь Орос улсын хүүхдүүд их сайн тоглодог. Сүүлийн үед Хятад улсын тамирчид их хүч төрөн гарч ирж байна л даа, даамны төрөлд. Миний шийдвэрлэх тоглолт хийсэн тамирчин маань ч Хятад улсын тамирчин байсан. Наймдугаар өргийн дараа хоёрдугаарт явж байсан учраас хожихын төлөө тоглоогүй. Тэнцвэл медальт байрт буух байсан болохоор тэнцэх зорилготой тоглож байсан. Гэтэл хятадын тамирчин буруу нүүдэл хийчихсэн. Би дэлхийн аварга болчихоод өөртөө итгэж өгөхгүй л байсан. Яах вэ, сүүлийн үед туркууд даамын тэмцээнийг сонирхож, эх орондоо зохион байгуулах болсон. Энэ жилийн тэмцээний зохион байгуулалт, тамирчдыг байрлуулах байр, хоол, ундны асуудал их сайн байсан. Магадгүй цаг агаарын байдал, идэж байгаа хоол унд маань таарсан болохоор сайн тоглосон байх.

**-Тамирчин хүн бүрт тэмцээнд оролцохоосоо өмнө өрсөлдөгчөө судлах гэдэг том зүйл байдаг. Чиний хувьд судалгаа хэр хийв?**

-Би тэмцээнд явахаасаа өмнө орос улсын тамирчин Марель Шарапутдинов, Иван Бусирцов, Анатоли Протодяконовыг их судалсан. Тэр гуравтайгаа ч таарч тоглосон. Бид тоглож байхдаа өргөө бичиж тэмдэглэдэг. Тэр тэмдэглэлийг шүүгчид аваад интернэтэд байршуулдаг. Миний хувьд өрсөлдөгчдийнхөө тоглолтыг интернэтээс судалж, анализ хийсэн. Энэ жил өмнө нь нэг удаа тоглосон Анатоли Протодяконовтой дахин таарсан. Бид орчин үеийн идэвхтэй тоглолт үзүүлсэн. Тэр нь бие бие рүүгээ дайрах маягийн тоглолт гэсэн үг. Энэ тоглолтоор дахин тэнцсэн. Өмнөх удаагийн тоглолт дээрээ ч тэнцэж байсан юм.

**-Ангийнхан болон багш нар чинь чамайг тосч авч байгаа харагдсан?**

-Манай ангийнхан намайг маш сайхан угтаж авсан. Би үнэхээр их баярласан. Бүгд миний зургийг барьчихсан, баяр хүргэе, дэлхийн аварга хэн билээ. шийрэв, шийрэв гээд л хашгарч байсан. Тэр үед их сайхан санагдсан. Хамт олонтой байх ямар сайхныг мэдэрсэн. Мөн манай даамны холбооныхон болон их мастерууд маань биднийг тосч авсан. Бүгдэд нь баярлалаа гэж хэлмээр байна. Нэг хүнд баярлалаа гэж хэлмээр байна. Би дэлхийн аваргын тэмцээнд явах эрхээ авсан ч санхүүгийн байдлаас болж яавах эсэх нь эргэлзээтэй болсон л доо. Бараг л явахгүй гээд бодчихсон байсан. Тамирчин хүн аливаа тэмцээн уралдаанд явахад санхүү маш их чухал байдаг. аав, ээж минь тэр болгонд намайг дэмжиж, тэмцээн алгасалгүй оролцуулдаг. Энэ жил улс орны санхүүгийн хямрал, ам.долларын ханш өссөнөөс болоод Туркийн тийзний үнэ өсчихсөн. Өнгөрсөн жил нэг сая 100 мянга байсан бол энэ жил хоёр сая болтлоо өссөн. Дэлхийн аваргад явъя гэвэл тийзний мөнгөнөөс гадна, идэх, уух, ойр зуурын зүйлд зарцуулах зардал нийлээд гурван сая гаруй төгрөг шаардлагатай болсон. Аав, ээжид маань шаардлагатай мөнгөний тал зардал нь байсан. Ивээн тэтгэгч, санхүүжилт ч олдохгүй байх үед аавын минь шавь Ганхуяг ах тал зардлыг минь даасан. Ингэж л тэмцээнд явах болсон. Тухайн үед тэмцээн болоход 14 хоног л үлдсэн байсан. Тэр хүнд баярлалаа гэж хэлмээр байна.



СПОРТ



# Л.ЦЭНД:

## БИДЭНД СЭТГЭЛЭЭСЭЭ АЖИЛЛАХ ДАСГАЛЖУУЛАГЧ ХЭРЭГТЭЙ БАЙСАН, ТЭГЭЭД Д.ЭНХБАЯРЫГ АМЕРИКААС ДУУДАЖ БАЙЛАА

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Дулаан орнуудад бол дугуйт тэшүүрийн уралдаан өндөр хөгжсөн. Зориулалтын талбайтай, хол зайд уралддаг юм билээ. Манайд бол тийм зориулалтын талбай байхгүй. Тийм болохоор дугуйт тэшүүрээр бэлтгэл хийлээ гээд нөлөө бага. Уг нь бол тэшүүр бүх хүн хичээллэж болохоор нийтлэг спорт. Эрэгтэй, эмэгтэй, хөгшин залуу гэлтгүй. Манай тамирчид 2016 онд маш их өндөр амжилт гаргалаа. Ялангуяа Б.Сумъяа гэж 17 настай охин байна. Дэлхийн Залуучуудын хоёрдугаар Олимпт оролцож, түрүүллээ. Багийн тэмцээнд оролцсон л доо. Д.Энхбаяр маань сугалаагаар Б.Сумъягийнхаа багтсан багийг дасгалжуулахаар таарсан. Б.Сумъяа хамгийн түрүүнд гарсан, их өндөр хурд гаргасан. Тэр хурдыг дараагийн тамирчид нь барьж чадсан. Их хүчтэй багууд байсан ч Б.Сумъягийн багтсан багийн амжилтад хүрч, хурдалж чадаагүй. Ийм л өндөр амжилт гаргасан. Энэ амжилтыг үнэлэх ёстой. Манай холбоо гэхэд л огт анхаарал хандуулаагүй, үнэлээгүй. Бусад спортынхныг хараад байхад Олимпийн наадмаас медаль авсан тамирчиндаа байр хүртэл өгөөд, дэмжээд байгаа харагдах юм. Гэтэл тэшүүрийн тамирчинд л таг. Манай холбоо муу ажиллаж байгаа байх. Хөөцөлдөхгүй л байгаа болов уу. Хөөцөлдвөл болохгүй юм гэж юу байх билээ. Би дотроо 17-хон настай охин Олимпийн аварга аваад ирж байхад нь сайхан хүлээж аваад, хоёр өрөө орон сууц өгчих юм болов уу гэж бодож байсан юм. Олимпийн аварга гэдэг бол хэн дуртай тамирчинд нь олддог алдар, амжилт ч биш. Хэдийгээр улсуудын хамтарсан баг байсан ч гэсэн энэ бол маш том амжилт.

**-Хэрвээ манай тамирчид битүү дээвэртэй ордонтой, системтэй бэлтгэл хийдэг бол том амжилт гаргаж чадахыг харуулсан үйл явдал шүү, энэ?**

-Яг тийм. Энэ хүүхэд цөөхөн хоногСолонгостбэлтгэлхийгээд, Хятадад бас хэд хоносон байх. Үндсэндээ 20 гаруйхан хоног бэлтгэл хийчихээд л 7-8 сар гулгасан тамирчидтай уралдсан. Хоёрдугаарт, Олимпийн наадамд оролцоно гэхээр л хэн дуртайг нь авчихдаг юм биш. Дэлхийн шилдэг 25 хүнийг сонгож авдаг. Б.Сумъяа шилдэг 25 тамирчинд багтаад, Олимпийн наадамд оролцож, амжилт үзүүлээд ирсэн. Тийм болохоор үнэлэх ёстой гэж би ойлгодог. Үнэлэхгүй болохоор нь багш нь жаахан гоморхож л явна. Яагаад гоморхоод байна вэ гэхээр, энэ бол миний отгон шавь. 10 настай байхад нь би аав, ээжтэй нь уулзаж, сонгож авсан юм. Дарханы хүүхэд шүү дээ. Тэгээд эцэг, эхэд нь "Хотод аваад ир. Би Баянгол дүүргийг хариуцаад, хэдэн хүүхэд бэлтгээд явдаг юм. Энд сургууль соёлд оруулаад, бэлтгэл хийлгэе" гэсэн. Миний саналыг аав, ээж нь хүлээж авч, хүүхдээ хотод авч ирсэн юм. Зургаан жил миний удирдлагад бэлтгэл хийсэн. Харин сүүлийн жил гаруй хугацаанд Д.Энхбаяртай хамт бэлтгэл хийж, тэмцээн, уралдаанд оролцож байна. Д.Энхбаяр чинь миний шавь болохоор бид хоёрын сургуулилт, бэлтгэл хийлгэх аргад нэг их хол зөрөө байхгүй.

**-Манай улсад тэшүүрийн спортоор хичээллэж байгаа хүүхэд, залуучууд цөөн байна уу. Эсвэл амжилт гаргаж байгаа нь цөөхөн болохоор тэгж харагдаад байна уу?**

-Үгүй ээ, цөөн биш, харин ч олон байгаа. Одоо бол гулгадаг талбай нь цөөхөн болчихоод байна. Улаанбаатар хотод намайг тамирчин байхад стандартын шаардлага хангасан гурван гулгуурын талбай байлаа. Гэтэл одоо хөдөө Хөвсгөл, Орхон аймагт л стандарт талбай байна. Ингээд л болоо. Хэрвээ гулгуурын талбайтай бол маш олон залуучууд сонирхож, хичээллэнэ. Ялангуяа бид өвлийн спортын битүү дээвэртэй ордонтой болчихвол ганцхан гүйлтийн тэшүүр биш уран гулгалт, хоккей, шорт трек гээд олон спорт зэрэг хөгжих боломжтой. Тиймээс л битүү гулгуурын талбайтай л болох хэрэгтэй байна. Тэгэхгүй бол хэчнээн тамирчдыг "нүдээд" өндөр амжилт гаргахгүй. Нэгэнт л бэлтгэл хийх нөхцөл байхгүй байхад яаж өндөр амжилт гаргах вэ дээ. Тэнд тамирчид гулгаж байхад бид энд дандаа л бие бялдрын, хүчний бэлтгэл хийж байна шүү дээ.

**-Өнөөдөр тэшүүрийн дасгалжуулагч хийх хүн Монголд тун цөөн байх шиг байна. Энэ тал дээр та юу хэлэх вэ?**

-Дасгалжуулагч үнэхээр хомс байна. Яагаад хомс байна гэхээр, нэгдүгээрт ажиллах нөхцөл маш хүнд. Тэгээд их бага цалин авдаг. Гадаа 20 гаруй градусын хүйтэнд мөсөн дээр зогсоод байх тийм амар биш шүү. Дээрээс нь хангамж муу. Тийм учраас аль болох дулаахан, тохьтой газар ажиллахыг хүснэ биз дээ. Яахав дээ, энэ ажилдаа дуртай хүмүүс нь л өнөөдрийг хүртэл явж байна. Бидний үед хэдэн сайхан хөгшчүүл байлаа. Дашням, Ламжав гавьяат, Санжаасүрэн гэх мэт олон хүн байсан. Өөрсдөө энэ спортод хайртай, дурлаж явсан учраас сэтгэлээрээ зүтгэж байж. Одоо бол сэтгэлээрээ зүтгэх бараг л алга байна.



*Дасгалжуулагч Д.Энхбаяр тэшүүрийн тамирчин байхдаа*

...Д.Энхбаяр маань энэ хэдэн хүүхдийг хаяж чадахгүй л байгаа. Энэ хэдэн хүүхдүүдийг дэмждэг газар гэж байхгүй, сэтгэлээрээ л бэлтгэл хийгээд яваад байна. Сая ч гэсэн яаж зардал мөнгийг нь олсон юм, бүү мэд. Цөөхөн хэдэн хүүхэд аваад Хятад явлаа л гэж байсан...

**-Залуучуудын Олимпийн аварга Б.Сумъяаг дасгалжуулж, энэ өндөр амжилтад хүргэсэн хүн нь дасгалжуулагч Д.Энхбаяр. Таны ууган шавь нарын нэг байх. Шавийнхаа талаар жаахан дурсамж дэлгээч?**

-Би үндэсний шигшээ багт 11 жил багтаж байгаад, 1972 онд Токиогийн Олимпийн наадамд оролцчихоод л зодог тайлсан. 32 нас хүрсэн болохоор больё гэж бодоод зодог тайлсан нь тэр. Тэгээд "Хоршоолол" нийгэмлэгийн орлогч даргаар ажилласан. Ерөнхийдөө спорт хариуцсан л хүн гэсэн үг. Тэнд нэг жил ажилласан. Тэгээд "Энэ миний ажиллах газар биш байна" гэж бодоод больсон. Түүнийхээ дараа Улаанбаатар хотын боловсролын хэлтэс дээр очоод, тухайн үед байсан Биеийн тамирын хүүхдийн орой сургуульд тэшүүрийн анги нээж ажиллах хүсэлтээ тавьсан. Тэд ч миний хүсэлтийг хүлээн зөвшөөрч, 1973 онд би тэшүүрийн анги нээсэн юм. 40-өөд хүүхэдтэй, хичээлийн бус цагаар заана. Тэнд л манай Д.Энхбаяр, Дагвадорж, Эрдэнэ-Өлзий гэх мэт хүүхдүүд орж ирсэн. Тэр үеэс л тэшүүрийн спорт их сайхан болсон. Олон ч сайн тамирчид гарч ирсэн. Манай Д.Энхбаяр холын зайд маш сайн уралддаг, сайн тамирчин байсан. Яахав, сүүлдээ зах зээл ч гарсан, Д.Энхбаяр Солонгос, Америк явж ажилласан. Тухайн үед би шигшээ багт дасгалжуулагч хийж байсан. Гэвч бие жаахан муу, нас ч дээр гарсан. Тэгээд л "Ерөөсөө л Д.Энхбаярыг л дуудъя. Боломжийн хүн юм байгаа юм" гэж энэ хавиараа ярьж байгаад Америкаас дуудаад авч ирж байлаа даа.

**-Яагаад заавал Д.Энхбаяр дасгалжуулагч гэж. Өөр дасгалжуулагч үнэхээр олдоогүй юм уу. Эсвэл ур чадвараас авахуулаад бас бус зүйлийг нь харж сонгосон байх нь уу?**

-Тухайн үед дасгалжуулагч үнэхээр хомс болсон. Бидэнд яг л үнэн сэтгэлээсээ ажиллах хүн хэрэгтэй байсан юм. Тэгээд л Д.Энхбаярыгаа дуудаж авчирсан. Америкт боломжийн бизнес эрхэлж байсныг нь хэцүүдүүлсэн л дээ, бид. Сүүлд надад хэлж л байсан, багш тэгсэн шүү гээд. Тэр үедээ олон жил гадаадад байсан хүн нутагтаа ирье гэж санасан байх. Тиймдээ ч их дуртай ирсэн. Гэвч нөхцөл байдал, мөнгө төгрөг тийм ч таатай байгаагүй. Гэхдээ л Д.Энхбаяр өнөөдрийг хүртэл улсын шигшээ багт 10-аад жил ажиллачихлаа. Маш олон сайн тамирчин бэлтгэн гаргасан. Олон улсын хэмжээний мастер тамирчид төрүүлсэн. Г.Ууганбаатар, Б.Ургаацэцэг, Г.Мөнх-Амьдрал, Г.Мөнхдорж гээд л хөвөрнө. Хамгийн сүүлд Б.Сумъяаг дурьдаж болж байна. 17-хон настай хүүхэд. Цаашид олон сайхан амжилт гаргана даа. Энэ хүүхдийг Олимпийн наадамд түрүүлэхэд хамгийн гол нөлөөлсөн хүн бол Д.Энхбаяр. Тэр хүүхдийн бэлтгэлжилт таарч байна уу, юу нь дутаж байна, одоо яахав гэдэг чинь тэр хүний оюун ухаанаас шалтгаална. Тэгээд тамирчидтайгаа сайн харилцаж, учрыг нь олж ойлгуулж чадаж байна. Одоо чинь хүүхдүүдийн сэтгэл зүй өөр болсон. Хуучин шиг тэг гэж захиргаадаг үе өнгөрсөн. Би уржнангаас эхлээд мөсөн дээр зогсохоо больчихсон. Гэхдээ өнгөрсөн жил нэг удаа очоод харж байхад бэлтгэл хийж байгаа хүүхдүүд их цөөрсөн байна. Сайхан сайхан тамирчид байсан больчихож. Энэ бол холбооны л үйл ажиллагаатай холбоотой л доо.

**-Саяхан дасгалжуулагч Д.Энхбаяр тамирчдаа аваад Хятад руу явж бэлтгэл хийлээ. Бас асуудлыг чадахаараа л зохицуулж, тамирчдынхаа ур чадварыг нэмэх тал дээр ажиллаж байх шиг байна?**

-Одоо охидуудаас Б.Сумъяа, Д.Дэлгэрмаа, А.Зул гээд тамирчид байна. Эрэгтэйчүүдээс ч гэсэн овоо хэдэн сайхан тамирчин бий. Я.Зоригтбаатар, Д.Гочоосүрэн гээд тун сайн тамирчид байна. Д.Энхбаяр маань энэ хэдэн хүүхдийг хаяж чадахгүй л байгаа. Энэ хэдэн хүүхдүүдийг дэмждэг газар гэж байхгүй, сэтгэлээрээ л бэлтгэл хийгээд яваад байна. Сая ч гэсэн яаж зардал мөнгийг нь олсон юм, бүү мэд. Цөөхөн хэдэн хүүхэд аваад Хятад явлаа л гэж байсан. Би "Өөртөө ингэж лай удаж яах гээд байгаа юм" гэж загнасан. Гэтэл надад "Өөрийнхөө хөдөлмөрийн үр дүнг үзмээр байна шүү дээ багш аа" гэж байсан. Өнөөдөр ирэх эргээд ирэх. Гэтэл ирэхэд нь манайд мөс байхгүй. Хэзээ ч мөстэй болох юм, бүү мэд.

**-Уг нь өвлийн Олимпийн наадамд тамирчдаа оруулаад, мөсөн замд уралдуулчихвал?**

-Тэр хүний зорилго нь ерөөсөө л тэр. 2018 оны Олимпийн наадамд орох гээд л энэ хэдэн хүүхдийг бэлтгээд л байна. Гэхдээ Олимпийн нормтив биелүүлнэ гэдэг хэцүү. Нэг удаа биелүүлээд болчихдог юм биш. Гурван удаагийн тэмцээнд оролцож, бүгдэд нь Олимпийн нормтив биелүүлж байж оролцоно. Тэгээд тэшүүрийн спорт гэдэг секунд, долиор хэмжигддэг. Тийм болохоор маш хэцүү. Яахав, Олимпийн нормтив биелүүллээ. Гэтэл 25 хүн л оролцох ёстой. Залуучуудын Олимпийн эрх авахаар Я.Зоригтбаатар гэдэг хүү, Б.Сумъяа хоёр явсан. Гэтэл тэр хүч 100 гаруй хүн уралдаж байхад 31 дүгээр байрт шалгарч, маш сайн байсан. Харамсалтай нь 25 хүн л авах ёстой болохоор Олимпийн наадамд оролцож чадаагүй. Ийм л хэцүү спорт шүү дээ. Гэхдээ л миний шавь бэлтгэж байгаа хэдэн тамирчдаа Олимпийн наадамд оролцуулахын төлөө зүтгэж л явна даа.

NO STRESS

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр -6
Шөнө -18

Нөгөөдөр

Өдөр -10
Шөнө -14

## Өдрийн зурхай

**ӨВЛИЙН ЭХЭН ШАРАГЧИН ГАХАЙ САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ТАХИА ӨДӨР**

**Аргын тооллын:** *2016.11.11, Баасан гараг*
**Наран ургах шингэх:** *07.52-17.20*
**Үс засуулбал:** *Өвчин эмгэг ирнэ*
**Барилдлага:** *Идэр*
**Шүтэн барилдлага:** *Сансар*



Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэх, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олдох болой. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой.

# Ж.НАРАНТУНГАЛАГ өнөөдөр МАРАТ ГАФУРОВААС даагаа нэхнэ



Холимог тулааны “One Championship”, “Legend FC” холбооны дэлхийн аварга асан, гавьяат тамирчин, “Чингисийн цавчилт” хочит Ж.Нарантунгалаг дэлхийн аваргын төлөө “Кобра” хочит, ОХУ-ын тулаанч Марат Гафуровтой өнөөдөр Сингапурт тулалдана. Энэхүү тулааныг аваргын бүс, алдагдсан нэр хүндээ буцаан авах тулаан хэмээн манайхан онцолж буй юм. Учир нь жилийн өмнө “ONE Championship”-ийн дэвжээн дээр тэд анх удаа тулалдахад Марат Гафуров манай тулаанчийг боох мэхээр ялж байсан билээ. Тэгвэл хариу тулааны хэвлэлийн бага хурал өнгөрсөн лхагва гарагт боллоо. Хурлын үеэр Монгол Улсын тамирчин Ж.Нарантунгалаг “Цэвэр ялж, дэлхийн аваргын бүсээ эргүүлэн авахын төлөө хичээнэ ээ. Босоо байрлалаас түлхүү тулалдах зорилготой” хэмээн ярьсан байна. Тэгвэл түүний өрсөлдөгч Марат Гафуров “Жадамбааг сайтар судалж байна. Өмнөхөөсөө ч хурдан хугацаанд ялж, аварга цолоо хамгаалах зорилготой. Амаргүй нь ойлгомжтой. Тэр ч бас намайг ялахыг хүсч байгаа. Би тулаанд бэлэн” хэмээн “One Championship” холбооны албан ёсны сайтад өгсөн ярилцлагадаа өгүүлжээ. Тэгвэл Сингапурын төв ордонд явагдах “ONE Championship”-н энэ жилийн хамгийн том, хамгийн дуулиантай энэхүү тулааныг “SPS HD” телевиз шууд дамжуулан үзүүлэх болно. Тулаан өнөөдөр 19:00 цаг эхлэх юм. “Defending Honor” хэмээх уг эвентийн өөр нэг онцлох тулаан ММА-гийн домог Японы Шиная Аоки болон Филиппиний Эдуард Фолаянг нарын дунд явагдах юм. Гурван жилийн өмнө “ONE Championship”–н хөнгөн жингийн аварга болсон Аоки аваргын бүсээ хамгаалах гурав дахь тулаанаа ийнхүү хийх гэж байна.

FOOTBALL NEWS

## ГОЛЛАНД талбайдаа БЕЛЬГИТЭЙ тэнцлээ

Н.ПУНЦАГБОЛД

Европын хөлбөмбөгийн шигшээ багууд нөхөрсөг тоглолт хийж эхэллээ. Өнгөрсөн лхагва гарагийн шөнө Голландын шигшээ баг талбайдаа Бельгийн хүчирхэг шигшээг хүлээж авч, 1:1-ээр тэнцлээ. Бельгээс тоглолтын довтолгооны шугаманд ах, дүү Азарууд тоглосон нь энэ “тулаан”-ы онцлог байлаа. Тоглолтын 38 дахь минутад Классен торгуулын цохилтоос тооны харьцааг нээж, Голланд тэргүүлж эхэлсэн.

Гэвч 82 дахь минутад Феррейра Карраско тэнцүүлж, форм сайтай байгаагаа харууллаа. Мөн энэ өдөр Гркийн шигшээ баг талбайдаа Беларусийг хүлээж авч, 0:1-ээр хожигдлоо. Тоглолтын хувь заяаг шийдсэн цорын ганц гоолыг 14 дэх минутад Политевич оруулжээ.



## РОНАЛДО “Реал”-аас жилийн 23.6 САЯ ЕВРОГИЙН цалин авна

Испанийн алдарт “Реал Мадрид” клубын довтлогч Криштиано Роналдо багтайгаа гэрээгээ сунгаж, дэлхийн хамгийн өндөр цалинтай хөлбөмбөгч болсон билээ. Шинэ гэрээ ёсоор тэрбээр “Реал”-аас жилдээ татварын дараа 23.6 сая еврогийн цалин авах ажээ. Ингэснээр Роналдо 2021 он хүртэл “Реал”-д тоглохдоо 118 сая еврогийн цалин авах юм байна. Өмнө нь тэрбээр “Реал”-аас урамшуулал орохгүйгээр жилд 21 сая еврогийн цалин авдаг байжээ. Мөн тэрбээр спортын бараа үйлдвэрлэгч Nike-тай спонсорын шинэ гэрээ байгуулсан юм. Ингэснээр тэрбээр тус компаниас жилдээ 24 сая евро авах бөгөөд энэ “Реал”-аас авдаг цалинтай нь тэнцэж байгаа билээ. Тэгвэл Nike түүхэндээ анх удаа хөлбөмбөгийн тамирчинтай ийм том гэрээ хийж байгаа нь энэ юм байна. 1984 онд Nike компани үүнтэй ойролцоо үнийн дүнтэй гэрээг сагсан бөмбөгийн домогт тамирчин Майкл Жордантай байгуулж байжээ. Дашрамд дурьдахад, Роналдо өмнө нь Adidas-тай хамтарч ажиллаж байсан билээ.

